



**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**

MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY

ШУТИС-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ, АУДИТЫН ДҮГНЭЛТ

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЛБА

2025.06.03

ОРШИЛ

- Тайлант онд оюутны сурах орчин, нөхцлийг сайжруулах, олон талт орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд төсөл, гэрээт ажлаас орлого олох, багш, ажилтны цалинг нэмэгдүүлж, тэвчиж болох зардлуудыг гаргахгүй, зардлыг үр ашигтай төсвийн дагуу захиран зарцуулах, бүтцийн өөрчлөлт хийж ажлын байрны давхардлыг арилгах, орон тоог бууруулах чиглэлд анхааран ажилласан.
- ШУТИС-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн шинжилгээнд бүрэлдэхүүний 11 сургууль, НБТөв, 2 Ахлах сургууль, ТКоллеж, ҮТС-МСҮТ, Захиргаа, Эрдэм шинжилгээ инновацийн газар, Хэвлэлийн газар, Шинжлэх ухаан технологийн номын сан, Төвлөрсөн зэрэг нийт 21 нэгжийн санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан.
- Тайлант хугацаанд нийт 1448 орон тоотойгоос үндсэн орон тооны профессор, багш 817 ажилласан байна. Нийт оюутны тоо: Хавар, намрын улиралд идэвхтэй сурч буй сонголт хийсэн бакалавр оюутны дундаж 12,608, магистр 1,108, доктор 174, МСҮТ, ахлах сургуулийн 1,497 суралцагч суралцсан байна.

- Балансын бүтцийн шинжилгээ
- Орлогын шинжилгээ
- Зардлын шинжилгээ
- Нэг оюутанд ноогдож буй зардлын шинжилгээ
- Оюутны байрны орлого, зардлын шинжилгээ
- Санхүүгийн харьцааны шинжилгээ
- Дүгнэлт
- Аудитын дүгнэлт



БАЛАНСЫН БҮТЦИЙН ШИНЖИЛГЭЭ /сая.төг/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2023 он	Дүнд эзлэх хувь	2024 он	Дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					Абсолют	Харьцангуй
Мөнгөн хөрөнгө	28,247.5	17.1	36,831.6	22.2	8,584.1	30.4
Авлага	3,174.2	1.9	2,093.5	1.3	(1,080.7)	34.1
Урьдчилгаа	338.5	0.2	1,258.7	0.8	920.2	271.8
Бараа материал	1,952.4	1.2	1,758.7	1.1	(193.7)	9.9
НИЙТ ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	33,712.6	20.5	41,942.5	25.3	8,229.9	24.4
Үндсэн хөрөнгө	131,023.7	79.5	123,796.8	74.7	(7,226.9)	5.5
НИЙТ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	131,023.7	79.5	123,796.8	74.7	(7,226.9)	5.5
НИЙТ ХӨРӨНГӨ	164,736.3	100.0	165,739.3	100.0	1,003.0	0.6
Богино хугацаат өр төлбөр	14,410.3	8.7	17,581.3	10.6	3,171.0	22.0
Урт хугацаат өр төлбөр	42.2	0.0	37.3	0.0	(4.9)	11.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,452.5	8.7	17,618.6	10.6	3,166.1	21.9
Засгийн газрын оруулсан капитал/ЗГСан/	30,687.5	18.6	30,687.5	18.5	-	-
Хуримтлагдсан үр дүн	58,495.5	35.5	56,333.3	34.0	(2,162.2)	3.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	61,100.8	37.1	61,100.1	36.9	(0.7)	(0.0)
НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ	150,283.8	91.2	148,120.9	89.4	(2,162.9)	1.4
ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧИЙН НИЙТ ДҮН	164,736.3	100.0	165,739.3	100.0	1,003.0	0.6

Балансын бүтцийг авч үзвэл нийт хөрөнгө 165,739.5 сая төгрөгт хүрч урьд оны мөн үетэй харьцуулахад 0.6% буюу 1,003.2 сая төгрөгөөр нэмэгджээ. Эргэлтийн хөрөнгө 25.3 хувийг, эргэлтийн бус хөрөнгө 74.7 хувийг эзэлж, эргэлтийн хөрөнгө 3.9 пунктээр өссөн байна. Эх үүсвэрийн хувьд өр төлбөр 10.6 хувь, эзний өмч 89.4 хувийг тус тус эзэлж байна.



ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Эргэлтийн хөрөнгө мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материалаас бүрдэж байна. Мөнгөн хөрөнгө 22.2 хувь буюу 8,584.1 сая төгрөгөөр, урьдчилгаа 920.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, авлага 1.3 хувь буюу 1,080.7 сая төгрөгөөр, бараа материал 193.7 сая төгрөгөөр тус тус буурсан дүнтэй гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 36.8 тэрбум төгрөг, үүнээс 12.4 тэрбум төгрөг нь сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого, 655.6 сая төгрөг нь оюутны байрны урьдчилж орсон орлого, 4,217.8 сая төгрөг нь гэрээт ажил, төслийн урьдчилж орсон орлого, 5,204.6 сая төгрөгийн байгууллага болон сургууль хоорондын тооцооны өглөг байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 36.8 тэрбум төгрөгөөс урьдчилж орсон орлого, өглөгийг хасаж тооцсоноор цэвэр шилжих үлдэгдэл нь 14.4 тэрбум төгрөг байна. Цэвэр шилжих үлдэгдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3,684.2 сая төгрөг буюу 25.6%-иар өсжээ.



ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ШИНЖИЛГЭЭ										
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ҮЛДЭГДЭЛ, ЦЭВЭР ШИЛЖИХ ҮЛДЭГДЭЛ (сая төгрөгөөр)										
№	Сургууль, нэгжийн нэр	Нийт үлдэгдэл	Үүнээс:						Дүн	Цэвэр шилжих үлдэгдэл
			УОО-сургалтын төлбөр	УОО-ОБ-ны төлбөр	УОО-төсөл, гэрээт ажил, бусад	Өглөг-байгууллага	Өглөг-хүмүүс	Өглөг-СХТОО-оо		
1	БАС	1,346.5	2,188.0		441.4	6.4			2,635.8	-1,289.3
2	БАТС	7.6	132.1		20.5	19.0	2.7	175.4	349.7	-342.1
3	БүХС	945.7	596.8	202.3	28.7	10.2	0.3		838.3	107.4
4	ГУУС	2,464.4	1,575.4		1,209.1	12.5	44.3	55.9	2,897.2	-432.8
5	ГХС	2,123.4	100.8		312.9		2.3		416.0	1,707.4
6	ДарТС	2,175.5	853.3	92.1	86.2	0.7	20.5		1,052.8	1,122.7
7	МехТС	268.2	771.1	66.3	53.2	12.5	3.2	280.0	1,186.3	-918.1
8	МХТС	2,991.3	2,182.6	112.4	81.2	12.2	10.7		2,399.1	592.2
9	ҮТС	592.6	855.6		349.2	6.3	1.3		1,212.4	-619.8
10	ХШУС	2,165.9	256.8	182.5	318.4		36.8		794.5	1,371.4
11	ЭХС	1,541.7	1,605.4		102.8	16.8			1,725.0	-183.3
12	НБТөв	221.3	45.1		168.4				213.5	7.8
13	КТК	1,374.5	619.2				1.2		620.4	754.1
14	ЕБАС	1,928.5	528.9				1.8		530.7	1,397.8
15	ДаТС-АС	297.9	82.9						82.9	215.0
16	Захиргаа	754.2				37.9			37.9	716.3
17	ЭШИГ	780.5			174.0				174.0	606.5
18	ХГ	264.2							0.0	264.2
19	ТНС	177.0				16.8			16.8	160.2
20	Төвлөрсөн	14,410.7			871.8	416.9		4,000.0	5,288.7	9,122.0
	Нийт дүн	36,831.6	12,394.0	655.6	4,217.8	568.2	125.1	4,511.3	22,472.0	14,359.6

Авлага урьд оны мөн үетэй харьцуулахад 34 хувь буюу 1,080.9 сая төгрөгөөр буурсан байна. Хан-Уул дүүрэг болон Орхон аймгийн шүүхийн тогтоолоор 7 оюутны 11.6 сая төгрөг, Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 12 тоот тогтоолоор 1570 оюутны 828.7 сая төгрөгийн сургалтын төлбөрийн найдваргүй авлагыг хүчингүй болгохоор шийдвэрлэсэний дагуу данснаас хассан. Тайлант оны жилийн эцсийн байдлаарх авлагыг төрлөөр харуулбал:

- сургалтын төлбөрийн авлага хувиараа төлөх оюутны авлага 1,238.9 сая төгрөг буюу 59.2%
- байгууллагатай холбоотой 579.9 сая төгрөг буюу 27.7%
- хувь хүнтэй холбоотой 274.6 сая төгрөг буюу 13.1% тус тус байна.

Сургалтын төлбөрийн авлага

Авлагын ангилал	Мөнгөн дүн /сая.төг/	Эзлэх хувь
Бакалавр	548.1	44.2
Магистр	399.6	32.3
Доктор	73.5	5.9
КТК, АС-ийн суралцагч	217.7	17.6
Дүн	1,238.9	100.0

Сургалтын төлбөрийн авлагын 44.2% нь бакалавр, 32.3% нь магистр, 5.9% нь доктор, 17.6% нь ахлах болон КТК-д суралцагчдын авлага байна.

АВЛАГА /сая.төг/

Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн авлага /сая.төг/

Сургууль, нэгжийн нэр	2023 он	2024 он	Үүнээс			Өөрчлөлт		Нийт авлагад эзлэх %
			Сургалтын төлбөр	Байгуул- лагаас авах	Хүмүүсээс авах	Тоогоор	Хувь	
БАС	182.8	59.6	59.6	-	-	(123.2)	32.6	2.8
БАТС	407.4	202.3	202.3	-	-	(205.1)	49.7	9.7
БУХС	280.8	235.0	187.7	7.5	39.8	(45.8)	83.7	11.2
ГХС	64.8	56.0	3.0	-	53.0	(8.8)	86.4	2.7
ГУУС	472.6	189.2	170.0	16.9	2.3	(283.4)	40.0	9.0
ДТС	223.1	164.1	154.8	-	9.3	(59.0)	73.5	7.8
МехТС	184.9	138.3	93.6	0.6	44.1	(46.6)	74.8	6.6
МХТС	233.3	233.9	36.8	180.7	16.4	0.6	100.3	11.2
ҮТС	103.5	47.3	43.1	-	4.2	(56.2)	45.7	2.3
ХШУС	13.2	3.3	3.3	-	-	(9.9)	25.2	0.2
ЭХС	208.2	48.6	47.7	0.9	-	(159.6)	23.3	2.3
ЕБАС	201.2	195.2	127.3	52.3	15.5	(6.0)	97.0	9.3
КТК	95.3	71.7	71.7	-	-	(23.6)	75.2	3.4
ДаТС-АС	47.5	18.7	18.7	-	-	(28.8)	39.3	0.9

АВЛАГА /сая.төг/

НБТ	82.7	19.4	19.4	-	-	(63.3)	23.4	0.9
ХГазар	27.2	1.0	-	1.0	-	(26.2)	3.7	0.0
ТНС		18.1	-	1.6	16.5	18.1		0.9
ЭШИГ	89.3	128.2	-	56.0	72.1	38.9	143.5	6.1
Захиргаа	2	4.6	-	3.4	1.2	2.6	229.6	0.2
Төвлөрсөн	254.6	259.1	-	259.1	-	4.5	101.7	12.4
ДҮН	3,174.4	2,093.5	1,238.9	579.9	274.6	(1,080.9)	66.0	100.0

Авлагыг МХТС, ТНС, ЭШИГ, Захиргаа, Төвлөрсөн нэгжүүд өмнөх оноос нэмэгдүүлж, бусад сургууль, нэгжүүд 6.0-283.4 сая төгрөгөөр бууруулсан байна. Нийт авлагад БуХС, МХТС, Төвлөрсөн нэгж 10-аас дээш хувийг эзэлж байна.

Бараа материалын үлдэгдэл нь оны эхэнд 1,952.4 сая төгрөг байсан бөгөөд тайлант хугацааны туршид 3,257.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 3,451.7 сая төгрөгөөр хорогдож, жилийн эцэст 1,758.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 193.7 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын нэмэгдсэн эх үүсвэрийг авч үзвэл:

- Бараа материалыг өөрийн хөрөнгөөр худалдан авсан – 3,187.9 сая төгрөг
- Төсвийн хөрөнгөөр -0.06 сая төгрөг
- Үнэ төлбөргүй -62.0 сая төгрөг
- Бусад хэлбэрээр -2.6 сая төгрөг байна.

Бараа материалын бүтцийн хувьд тусгай зориулалттай материал- 68.8, бичиг хэргийн материал 10.3, бусад материал 10.9, бэлэн бүтээгдэхүүн 3.5, аж ахуйн материал 2.1, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс 2.5, засварын материал, хүнсний материал 2.1 хувийг тус тус эзэлж байна.

Бараа материалын үлдэгдэл тайлант жилд 2022 оноос 23.9 хувиар, 2023 оноос 9.9 хувиар тус тус буурчээ. Төрийн хэмнэлтийн хуулийн 15.1.6 заалтаар бараа материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материалыг бэлтгэх нөөцлөх гэж заасны дагуу дийлэнх сургуулиуд бараа материалыг бууруулсан боловч ГУУС, ГХС, ХШУС, ЭХС, ХГ, ШУТНС, Захиргаа нэгжүүд өмнө оноос өсгөсөн байна.




БАРАА МАТЕРИАЛ /сая.төг/

Сургууль	2022 он	2023 он	2024 он	Өссөн, буурсан		Дүн эзлэх хувь
				2024/2022	2024/2023	
БАС	29.3	25.6	21.2	(27.6)	(17.2)	1.2
БАТС	15.6	15.0	14.4	(7.7)	(4.0)	0.8
БУХС	41.3	51.6	17.1	(58.6)	(66.9)	1.0
ГХС	21.6	5.1	31.6	46.3	519.6	1.8
ГУУС	3.1	6.4	32.5	948.4	407.8	1.8
ДТС	20.9	20.8	20.9	-	0.5	1.2
МехТС	535.9	599.0	469.7	(12.4)	(21.6)	26.7
МХТС	317.5	55.7	46.0	(85.5)	(17.4)	2.6
ҮТС	932.7	874.5	783.7	(16.0)	(10.4)	44.6
ХШУС	16.4	22.4	32.7	99.4	46.0	1.9
ЭХС	26.6	24.8	38.0	42.9	53.2	2.2
ЕБАС	10.7	8.2	5.9	(44.9)	(28.0)	0.3
КТК	158.5	92.5	58.9	(62.8)	(36.3)	3.3
НБТ	0.4	2.9		(100.0)	(100.0)	-
ҮТС-МСҮТ	2.8			(100.0)		-
ХГазар	10.2	12.7	21.9	114.7	72.4	1.2
ТНС	1.0	2.3	4.5	350.0	95.7	0.3
ЭШИГ	2.6	1.3		(100.0)	(100.0)	-
Захиргаа	164.9	131.6	159.5	(3.3)	21.2	9.1
ДҮН	2,312.0	1,952.4	1,758.5	(23.9)	(9.9)	100.0

ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгө тайлант жилийн эхэнд 186.2 тэрбум төгрөгийн балансын үнэ, 55.1 тэрбум төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий байсан бол жилийн эцэст үндсэн хөрөнгийн хэмжээ 188.5 тэрбум төгрөгт хүрч, хуримтлагдсан элэгдэл 64,7 тэрбум төгрөг болсон байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 1.2 хувиар буюу 2.3 тэрбум төгрөгөөр өсчээ.



Тайлант онд нийт бэлтгэсэн хөрөнгийн 54.9 хувийг өөрийн хөрөнгөөр, 11.3 хувийг улсын төсөв, гадаадын буцалтгүй хандив тусламж, аж ахуйн нэгж байгууллагаас үнэ төлбөргүй бэлтгэжээ. Тухайлбал ДаТС улсын төсвийн хөрөнгө оруулалт 300.0 сая төгрөг, МехТС Япон, Тоёота Сейлс Монголиа 44.7 сая төгрөг, дотоодын аж ахуй нэгж, төгсөгчид хандивлагчдаас БАС, БАТС, БУХС, ГУУС, ГХС, ДаТС, МХТС, ХШУС, ЭХС, ХЕБАС, ШУТТНС 484.3 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном сурах бичгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэсэн байна.

Мөн ЭХС нь ТӨБЗГ-ийн 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 466 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Солонгос улсын буцалтгүй тусламжаар “Монгол улсад байгаль орчинд ээлтэй эрчим хүчний эко хотхон байгуулах туршилтын төсөл “-ийн хүрээнд бий болсон нийт 674,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүхий 1мВт.ц-ын цэнэг хураагууртай 200 кВт-ын нарны цахилгаан станцыг ЭХЯ-наас баланснаас балансад шилжүүлэн авсан.



БҮРЭЛДЭХҮҮН СУРГУЛИЙН ХАНДИВААР АВСАН ХӨРӨНГӨ, сая төг

ДД	Сургууль, нэгжийн нэр	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Гадаадын хандив тусламж	Дотоодын хандив тусламж	Дүн	Тайлбар
1	БАС			37.9	37.9	Ай Си Рөүд ХХК, Монголын авто замчдын холбоо, Престиж инженеринг ХХК, төгсөгчдөөс
2	БАТС			1.6	1.6	"Худалдаа, тээврийн удирдлагын мэргэшсэн зөвлөх инженерүүдийн холбоо" ТББ
3	БУХС			11.6	11.6	Леборс ХХК, төгсөгчдөөс
4	ГУУС			113.0	113.0	АМГТГазар, Бадрах энерги ХХК, төгсөгчдөөс
5	ГХС			7.7	7.7	Жи Энд Ди Девелопмент ХХК
6	ДаТС	300.0		79.3	379.3	Төгсөгчдөөс, Голомт банк,
7	МехТС		44.7		44.7	Тоёото Сейлс Монголиа ХХК
8	МХТС			2.5	2.5	МТ салбар багш нар
9	ХШУС			29.1	29.1	Монголын физикийн нийгэмлэг, Лайв вотер вулкан ХХК, төгсөгчдөөс
10	ЭХС			192.7	192.7	М-Си-Эс груп ХХК, Сүвэн-Уул ХХК, "ХБТБНэгдэл" ТББ, төгсөгчөөс
11	ЕБАС			2.5	2.5	Боловсролын ерөнхий газар
12	ТНС			6.4	6.4	Хувь хүмүүсээс
Нийт дүн		300.0	44.7	484.3	829.6	х



ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТӨРӨЛ, ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ, сая төг

Төрөл	Дүн	Хуримтлагдсан элэгдэл		Нийт хөрөнгөнд эзлэх хувь
		дүн	хувь	
Барилга, байгууламж	92,632.9	18,000.4	19.4	49.1
Авто тээврийн хэрэгсэл	569.0	487.1	85.6	0.3
Машин тоног төхөөрөмж	71,763.9	39,605.7	55.2	38.1
Тавилга эд хогшил	6,626.6	4,018.0	60.6	3.5
Түүх соёлын дурсгалт зүйлс	128.4			0.1
Номын фонд	2,857.2			1.5
Дуусаагүй барилга байгууламж	525.1			0.3
Бусад үндсэн хөрөнгө	281.7	171.3	60.8	0.1
Програм хангамж	5,594.2	2,451.1	43.8	3.0
Бусад биет бус хөрөнгө буюу газрын эрх	7,551.5			4.0
Нийт дүн	188,530.4	64,733.5	34.3	100.0

Нийт үндсэн хөрөнгийн 123.8 тэрбум төгрөг нь цэвэр үндсэн хөрөнгө, 64.7 тэрбум төгрөг нь хуримтлагдсан элэгдэл байна. Энэ нь цэвэр үндсэн хөрөнгө өмнөх жилийн мөн үеийнхээс 5.5 хувь буюу 7.2 тэрбум төгрөгөөр багасч, хуримтлагдсан элэгдэл 17.4 хувь буюу 9.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.



ҮНДСЭН ХӨРӨНГӨ, сая төг

Сургууль	2022 он	2023 он	2024 он	Өссөн, буурсан		Дүн эзлэх хувь
				2022/2023	2023/2024	
БАС	5,911.7	5,644.4	5,476.9	-267.3	-167.5	4.4
БАТС	295.0	246.9	243.9	-48.1	-3.1	0.2
БУХС	7,123.4	11,022.9	11,533.3	3,899.5	510.4	9.3
ГХС	381.9	511.1	486.6	129.2	-24.4	0.4
ГУУС	4,068.2	12,351.2	10,808.2	8,283.0	-1,543.0	8.7
ДаТС	16,325.5	15,782.4	15,823.7	-543.1	41.3	12.8
МехТС	17,119.1	17,704.1	15,441.3	585.0	-2,262.8	12.5
МХТС	17,554.5	19,974.4	17,631.2	2,419.9	-2,343.3	14.2
ҮТС	8,922.3	7,583.6	6,707.1	-1,338.7	-876.5	5.4
ХШУС	2,764.9	4,007.2	3,979.6	1,242.3	-27.6	3.2
ЭХС	12,465.7	12,162.7	11,780.2	-303.0	-382.6	9.5
ЕБАС	278.3	319.1	348.1	40.8	29.0	0.3
КТК	918.5	284.2	264.9	-634.3	-19.3	0.2
ДаТС-АС	39.4	111.3	90.1	71.9	-21.1	0.1
НБТ	320.4	303.5	191.6	-16.9	-111.9	0.2
ҮТС-МСҮТ	114.8	95.8	-	-19.0	-95.8	0.0
ХГазар	176.1	77.9	221.4	-98.2	143.5	0.2
ТНС	1,526.7	1,598.8	1,713.5	72.1	114.7	1.4
Захиргаа	37,575.6	21,242.4	21,055.4	-16,333.2	-187.1	17.0
ДҮН	133,882.0	131,023.7	123,796.8	-2,858.3	-7,226.9	100.0

ӨР ТӨЛБӨР, ЭЗНИЙ ӨМЧИЙН ШИНЖИЛГЭЭ

Нийт өр төлбөр дүнгээрээ 17,618.6 сая төгрөгт хүрч, урьд оны мөн үетэй харьцуулбал 22.0 хувь буюу 3,171.0 сая төгрөгөөр өсч, эзний өмчийн дүн урьд оноос 1.4 хувь буюу 2,162.2 сая төгрөгөөр буурчээ. Нийт өр төлбөр, эзний өмч өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.6 хувь буюу 1,003.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 165,739.3 сая төгрөгт хүрчээ.

Нийт өр төлбөрт: Богино хугацаат өр төлбөрийн эзлэх хувь 10.6 хувь болж, урьд оны мөн үетэй харьцуулбал 1.9 пунктээр өссөн байна. Богино хугацаат өр төлбөрт сургалтын төлбөрийн болон оюутны байрны урьдчилж орсон орлогын эзлэх хувь 98.2 хувь болж урьд оны мөн үетэй харьцуулбал 21.1 пунктээр өсчээ.

Урт хугацаат зээлийн төлбөр нь: ТӨХ-ны 436 тоот тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн “Улаанбаатар Дулааны Сүлжээ”ХК-ий зээлийн хөрөнгөөр бэлтгэсэн халаалтын цогц төхөөрөмжүүдийн төлбөр болох урт хугацаат зээлийн үлдэгдэл 37.3 сая төгрөг байна.

Эзний өмчийн Засгийн газрын хувь оролцоо 18.5 хувь, хуримтлагдсан үр дүн 34.0 хувь, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 36.9 хувь, богино хугацаат өр төлбөр 10.6 хувь байна.




ОРЛОГЫН ШИНЖИЛГЭЭ /сая.төг/

Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он		Өөрчлөлт		Нийт орлогод эзлэх %	2024/2023	3 жилийн дундаж
			төсөв	гүйц	Тоо	Хувь			
I.Үндсэн үйл ажиллагааны орлого	45,788.5	56,182.4	68,138.0	68,384.6	246.6	100.4	81.0	21.7	56,785.2
Сургалтын төлбөрийн орлого	42,460.8	52,134.0	62,954.2	62,764.6	(189.6)	99.7	74.3	20.4	52,453.1
Түр сургалтын орлого	3,327.7	4,048.4	5,183.8	5,620.0	436.2	108.4	6.7	38.8	4,332.0
II.Эрдэм шинжилгээний орлого	4,303.5	4,065.0	5,346.5	5,530.1	183.6	103.4	6.5	36.0	4,632.9
III.Туслах үйл ажиллагааны орлого	5,596.1	7,502.3	4,507.2	8,561.0	4,053.8	189.9	10.1	14.1	7,219.8
Оюутны байрны орлого	849.9	1,252.4	1,365.3	1,427.8	62.5	104.6	1.7	14.0	1,176.7
Түрээсийн орлого	104.8	66.9	101.4	122.2	20.8	120.5	0.1	82.7	98.0
Бусад орлого	4,641.4	6,183.0	3,040.5	7,011.0	3,970.5	230.6	8.3	13.4	5,945.1
IV.Төсвөөс санхүүжих	700.3	768.3	3,238.0	1,953.9	(1,284.1)	60.3	2.3	154.3	1,140.8
Нийт дүн	56,388.4	68,518.0	81,229.7	84,429.6	3,199.9	103.9	100.0	23.2	69,778.7

ОРЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

Тайлант онд нийт орлого 84,429.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, урьд оны мөн үеийн гүйцэтгэлээс 23.2 хувь буюу 15,911.6 сая төгрөгөөр өсөж, төсвийн орлогын гүйцэтгэл 103.9 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад:

- Сургалтын төлбөрийн орлого- 20.4 хувь буюу 10,630.6 сая төгрөгөөр
- Түр сургалтын орлого -38.8 хувь буюу 1,571.5 сая төгрөгөөр
- Эрдэм шинжилгээний орлого – 36.0 хувь буюу 1,465.1 сая төгрөг
- Бусад орлого 13.4 хувь буюу 828.0 сая төгрөгөөр
- Оюутны байрны орлого 14 хувь буюу 175.4 сая төгрөгөөр
- Төсвөөс санхүүжих орлого 1.5 дахин буюу 1,185.6 сая төгрөгөөр өссөн.
- Түрээсийн орлого 82.7 хувь буюу 55.3 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй гарчээ.



ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО /сая.төг/

Үзүүлэлт	2022 он	2023 он	2024		Өөрчлөлт/ Төсөв		Өөрчлөлт/2023	
			Төсөв	Гүйцэтгэл	Хувиар	тоогоор	Хувиар	тоогоор
1. Боловсролын зээлийн сан	1,420.2	1,715.2	1,750.0	3,864.2	220.8	2,114.2	225.3	2,149.0
2. Төлбөртэй сургалтын орлого	41,043.7	50,418.8	61,204.3	59,333.6	96.9	(1,870.7)	117.7	8,914.8
Бакалаврын сургалтын төлбөр	37,037.3	46,075.5	56,079.6	54,392.0	97.0	(1,687.6)	118.0	8,316.5
Магистрын сургалтын төлбөр	3,359.9	3,586.8	4,186.2	4,263.5	101.8	77.3	118.9	676.7
Докторын сургалтын төлбөр	646.5	756.5	938.5	678.1	72.3	(260.4)	89.6	(78.4)
3.Түр сургалтын орлого	3,324.6	4,048.4	5,183.8	5,186.9	100.1	3.1	128.1	1,138.5
ОРЛОГЫН ДҮН	45,788.5	56,182.4	68,138.1	68,384.7	100.4	246.6	121.7	12,202.3

Тайлант онд бакалаврын сургалтын төлбөрийн орлогын төсөв, гүйцэтгэлийг харьцуулан нөлөөлсөн хүчин зүйлийг авч үзвэл:

2024 онд сургалтын төлбөрийн орлогыг төсөвлөхдөө бакалавр 13,598, магистр 1,110, доктор 181, нийт 14,889 оюутан суралцахаар тооцсон. 2023-2024 оны хичээлийн жилийн хаврын улирал, 2024-2025 оны намрын улиралд сонголт хийсэн бакалавр тоо дунджаар 12,608 болж, төлөвлөснөөс 990 оюутан дутуу байснаас сургалтын төлбөрийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.



ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ, НЭГЖИЙН СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ (сая төг)

№	Сургууль, нэгжийн нэр	Төсөв	Гүйцэтгэл	өөрчлөлт	
				тоогоор	хувиар
1	БАС	9,392.8	9,827.7	434.8	104.6
2	БАТС	1,048.9	1,079.7	30.8	102.9
3	БуХС	4,614.0	4,528.6	(85.4)	98.1
4	ГУУС	7,517.7	7,519.5	1.8	100.0
5	ГХС	1,226.4	1,250.5	24.1	102.0
6	ДаТС	4,218.6	4,918.7	700.1	116.6
7	МехТС	5,694.3	5,454.8	(239.5)	95.8
8	МХТС	13,378.1	12,360.2	(1,017.9)	92.4
9	ҮТС	5,832.8	5,909.5	76.7	101.3
10	ХШУС	1,582.1	1,432.2	(149.9)	90.5
11	ЭХС	8,200.0	8,281.3	81.3	101.0
12	НБТөв	248.4	201.9	(46.5)	81.3
х	Нийт дүн	62,954.2	62,764.6	(189.6)	99.7

Сургалтын төлбөрийн орлогын төлөвлөгөөг БАС, БАТС, ГУУС, ГХС, ДТС, ҮТС, ЭХС биелүүлж, бусад сургуулиуд биелүүлээгүй байна.



ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

ТҮР СУРГАЛТЫН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ (сая төг)

№	Сургууль, нэгжийн нэр	ЕБАС, КТК, ДаТС-АС			Түр сургалт		
		Төсөв	Гүйцэтгэл	Биелэлт %	Төсөв	Гүйцэтгэл	Биелэлт %
1	БАС				15.0	19.3	128.7
2	БАТС						
3	БуХС					1.1	
4	ГУУС				650.0	704.8	108.4
5	ГХС				60.0	82.5	137.5
6	ДаТС				17.0	31.2	183.5
7	МехТС				117.5	151.5	128.9
8	МХТС				80.0	114.7	143.4
9	ҮТС				30.0	2.0	6.7
10	ХШУС				183.0	514.7	281.3
11	ЭХС				700.0	747.1	106.7
12	НБТөв				68.4	73.2	107.0
13	ЕБАС	1,327.5	1,204.3	90.7			
14	КТК	1,482.4	1,545.5	104.3			
15	ДаТС-АС	453.0	427.9	94.5			
	ДҮН	3,262.9	3,177.7	97.4	1,920.9	2,442.1	127.1

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОРЛОГО

Тайлант онд эрдэм шинжилгээний орлого нь 5.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.0 хувиар буюу 1,465.1 сая төгрөгөөр өссөн, төсөвтэй харьцуулахад 183.6 сая төгрөг буюу 3.4 хувиар давж биелсэн байна.

Тайлант онд ШУТСангаас 423.5 сая төгрөгийн 21 гэрээт ажил хийж гүйцэтгэсэн байна. /БАС 20.7 сая төгрөг, ГУУС 36.3 сая төгрөг, МХТС 253.5 сая төгрөг, ҮТС 63.0 сая төгрөг, ХШУС 47.1 сая төгрөг/ Дээд боловсролын шинэчлэл төслөөр 90.4 сая төгрөгийн төслийн ажил хийж гүйцэтгэжээ. (БАС-25.8 сая төгрөг, ГУУС 8.9 сая төгрөг, МехТС 35.9 сая төгрөг, МХТС 9.8 сая төгрөг, ҮТС 4.0 сая төгрөг, ХШУС 6.1 сая төгрөг)-ийн орлого бүрдүүлжээ. Гадаад, дотоод гэрээт ажил төслөөс бүх бүрэлдэхүүн сургуулиуд 5.0 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж ажилласан байна.

Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн эрдэм шинжилгээний орлогоос ЭШИГ-ын дансанд 271.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Эрдэм шинжилгээний орлогын нийт орлогод эзлэх хувь өнгөрсөн оноос 4.3 пунктээр өссөн байна.

Орлогын төрөл	2023 он	2024 он		Өөрчлөлт/ төсөв	
		Төсөв	Гүйцэтгэл	Тоогоор	Хувиар
Эрдэм шинжилгээний орлого /сая. төг/	4,065.0	5,346.5	5,530.1	183.6	3.4
Нийт орлогод эзлэх %	5.9	6.2	10.2	4.0	63.9

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОРЛОГО

БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ, НЭГЖИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОРЛОГЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ (сая төг)

№	Сургууль, нэгжийн нэр	2023 он	2024 он		Өөрчлөлт		ЭШО-д эзлэх %
			Төсөв	Гүйцэтгэл	хувиар	тоогоор	
1	БАС	917.3	785.0	956.4	121.8	171.4	17.3
2	БАТС	28.7	140.0	161.5	115.4	21.5	2.9
3	БуХС	127.4	40.0	139.9	349.8	99.9	2.5
4	ГУУС	921.7	1,200.0	1,042.5	86.9	(157.5)	18.9
5	ГХС	71.6				-	-
6	ДаТС	146.6	92.0	71.9	78.2	(20.1)	1.3
7	МехТС	180.2	474.2	271.9	57.3	(202.3)	4.9
8	МХТС	47.6	300.0	589.1	196.4	289.1	10.7
9	ҮТС	444.3	390.0	505.2	129.5	115.2	9.1
10	ХШУС	507.4	565.3	401.9	71.1	(163.4)	7.3
11	ЭХС	252.4	210.0	173.3	82.5	(36.7)	3.1
12	НБТөв	230.3	860.0	940.7	109.4	80.7	17.0
13	ЭШИГ	171.6	290.0	273.3	94.2	(16.7)	4.9
14	ЗАХИРГАА	17.0		2.5		2.5	0.0
	ДҮН	4,064.1	5,346.5	5,530.1	103.4	183.6	100.0

Эрдэм шинжилгээний орлогод БАС, ГУУС, НБТ-с бусад сургуулиуд эрдэм шинжилгээний орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна. Нийт эрдэм шинжилгээний орлогод БАС, ГУУС хамгийн өндөр хувийг эзэлж байна.

ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО /сая.төг/

Үзүүлэлт	2023 он	2024 он		Өөрчлөлт төсвөөс		Өөрчлөлт өмнөх оноос	
		Төсөв	Гүйцэтгэл	тоо	хувь	тоо	хувь
Түрээс	66.9	101.4	122.2	20.8	120.5	55.3	182.7
Оюутны байрны орлого	1,252.4	1,365.3	1,427.8	62.5	104.6	175.4	114.0
Хандив	816.1	193.6	240.4	46.8	124.2	(575.7)	29.5
Үйлчилгээ	2,142.8	1,470.0	2,643.9	1,173.9	179.9	501.1	123.4
Бусад	1,772.8	1,402.2	2,984.6	1,582.4	212.9	1,211.8	168.4
Хүүгийн орлого	1,451.2	109.7	1,142.1	1,032.4	1,041.1	(309.1)	78.7
ДҮН	7,502.2	4,642.2	8,561.0	3,918.8	184.4	1,058.8	114.1

Түрээсийн орлого: ШУТИС 23 шахам аж ахуйн нэгж, хувь хүнд цайны газар, талбай, мэйжик ТҮЦ-нүүдийн орлогыг оруулсан болно. Түрээсийн орлогын гүйцэтгэл 20.5 хувь буюу 20.8 сая төгрөгөөр давж биелжээ.

Хүүгийн орлого: Банкны харилцах дансанд хүү тооцогдсон, мөн ШУТИС арилжааны банканд хадгалуулсан хадгаламжаас 1,142.1 сая төгрөгийн орлогыг олжээ.

Хандивын орлого: БАС 76.9 сая төгрөг, БУХС 15.9 сая төгрөг, ГУУС 91.9 сая төгрөг, МехТС 34.8 сая төгрөг, МХТС 10.6 сая төгрөг, ХШУС 3.6 сая төгрөг, ЭХС 6.5 сая төгрөгийн хандивын орлогыг бүрдүүлжээ.

Үйлдвэрлэл үйлчилгээний орлого: ҮТС-иас цайны газрын орлого 821.4 сая төгрөг, ХГазар 471.1 сая төгрөг, ГХС-ийн англи хэлний академийн орлого 928.3 сая төгрөг, МехТС-278.4 сая төгрөг, ЭХС-120.1 сая төгрөгийн орлогуудыг олжээ.

Бусад орлого: Захиргааны нэгж диплом ромбоны үнэ, элсэлтийн бүртгэл, тендерийн бичиг баримт, шинэ элсэгчийн эрүүл мэндийн үзлэг, бүрэлдэхүүн сургууль нэгжүүд оюутны үйлчилгээний орлого, хичээл таслалт, сэтгүүлийн орлого гэх мэт орлогууд орсон.

ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ ОРЛОГО /сая.төг/

Тайлант онд төсвөөс санхүүжигдэх орлогын ШУТИС-ийн ЕБАС, ДаТС-ийн ЕБАС-ийн хувьсах зардалд 376.0 сая төгрөг, ТК-ийн хүүхдийн хувьсах зардалд 126.9 сая төгрөг, Дээд боловсролын хуулийн дагуу байр ашиглалтын тогтмол зардлын 9-12 сарын санхүүжилтэнд 935.0 сая төгрөг, Сангийн яамнаас номны орчуулгын зардал 500.0 сая төгрөг тус тус орж ирсэн.

Үзүүлэлт	2023 он	2024 он			Өөрчлөлт төсвөөс		Өөрчлөлт өмнөх оноос
		Төсөв	Гүйцэтгэл	тоогоор	хувиар	тоогоор	хувиар
Лицейн хувьсах зардлын санхүүжилт	176.6	287.6	376.0	88.4	130.7	199.4	212.9
МСҮТ-ийн санхүүжилт	449	115.7	126.9	11.2	109.7	(322.1)	28.3
Хоолны зардал	35.7			-		(35.7)	-
Оюутны унааны хөнгөлөлт	107.1			-		(107.1)	-
Урсгал санхүүжилт		2,834.8	1,451.0	(1,383.8)	51.2	1,451.0	
ДҮН	768.4	3,238.1	1,953.9	(1,284.2)	60.3	1,185.5	254.3



ОРЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

Тайлант онд 84.4 тэрбум төгрөгийн орлого олжээ. Үүний 81.0 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого эзэлж байна.

Онууд	Орлогын гүйцэтгэл / сая.төг/	Харьцангуй өсөлт	Абсолют цэвэр	Суурь өсөлтийн коэф 2013	Хэлхээ өсөлтийн коэф	Цэвэр өсөлтийн 1 %-д ногдох орлого
2014	50,121.1					
2015	52,653.2	5.1	2,532.1	5.1	1.1	501.2
2016	46,997.9	(10.7)	-5,655.3	-6.2	0.9	526.5
2017	50,122.0	6.6	3,124.1	0.0	1.1	470.0
2018	52,025.6	3.8	1,903.6	3.8	1.0	501.2
2019	57,268.6	10.1	5,243.0	14.3	1.1	520.3
2020	45,485.2	(20.6)	-11,783.4	-9.2	0.8	572.7
2021	47,825.9	5.1	2,340.7	-4.6	1.1	454.9
2022	62,345.9	30.4	14,520.0	24.4	1.3	478.3
2023	68,518.0	9.9	6,172.1	36.7	1.1	623.5
2024	84,429.6	23.2	15,911.6	68.5	1.2	685.2
Дундаж	56,163.0	6.3	3,430.9	13.3	1.1	533.4

2014-2024 оны хооронд жилд дунджаар 56.2 тэр бум төгрөгийн орлого бүрдүүлж, жил тутам дунджаар 3.4 тэрбум төгрөгөөр өсчээ. Орлого өнгөрсөн оноос 23.2%-иар буюу 15.9 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарсан байна. Орлогын өсөлт 1 хувиар нэмэгдэхэд жилийн дундаж орлого 533.4 сая төгрөгөөр нэмэгдэж байна.



ЗАРДЛЫН ШИНЖИЛГЭЭ /сая.төг/

Зардлын ангилал	2022 он	2023 он	2024 он		Урьд оноос		Төсвөөс	
			Төсөв	Гүйцэтгэл	тоогоор	хувиар	тоогоор	хувиар
Сургалттай холбоотой шууд зардал	35,565.8	41,811.6	51,287.5	48,231.9	6,420.3	15.4	3,055.6	6.3
Шууд бус зардал	15,910.3	17,158.5	24,476.5	23,153.4	5,994.9	34.9	1,323.1	5.7
Оюутны үйлчилгээний зардал	343.5	472.7	531.3	471.9	(0.8)	(0.2)	59.4	12.6
Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааны зардал	4,821.8	5,194.9	7,576.8	6,740.5	1,545.6	29.8	836.3	12.4
Хөрөнгө оруулалт	3,807.2	1,764.1	1,199.1	1,168.7	(595.4)	(33.8)	30.4	2.6
ДҮН	60,448.6	66,401.8	85,071.2	79,766.4	13,364.6	20.1	5,304.8	6.7

Тайлант онд төсвийн зардлын гүйцэтгэл 79,766.4 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 5,304.8 сая төгрөгөөр дутуу 93.3%-ийн гүйцэтгэлтэй гарч урьд оны гүйцэтгэлтэй харьцуулбал 20.1 хувь буюу 13,364.6 сая төгрөгөөр өсчээ.

Нийт зардлын 83.4 хувийг сургалтын үйл ажиллагааны зардалд, 6.3 хувийг төсөл, гэрээт ажлын зардалд, 1.6 хувийг оюутны байрны зардалд, 3.6 хувийг МСҮТөв, ахлах сургуульд, 2.1 хувийг түр сургалт, 3.0 хувийг үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд тус тус зарцуулсан байна.


Бүтцээр урьд оны гүйцэтгэлтэй харьцуулан авч үзвэл:

- Сургалттай холбоотой шууд зардал 6,4205.2 сая төгрөгөөр
- Шууд бус зардал 5,994.9 сая төгрөгөөр
- Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааны зардал 1,545.6 сая төгрөгөөр өсөж
- Оюутны үйлчилгээний зардал 0.8 сая төгрөгөөр
- Хөрөнгө оруулалтын зардал 595.4 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй гарсан байна.

ЗАРДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Батлагдсан төсөвтэй харьцуулбал сургалттай холбоотой шууд зардал 3,055.8 сая төгрөг буюу 94.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

- Цалин нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,507.1 сая төгрөг
- Хичээл практикийн зардал 947.2 сая төгрөг
- Гадаад дотоодын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зардал 64.8 сая төгрөг
- Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс 50.9 сая төгрөг,
- Мэдээлэл суртачилгааны зардал 38.0 сая төгрөг
- Дотоод албан томилолт 41.1 сая төгрөг
- Ном хэвлэл 37.8 сая төгрөг
- Багшийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх зардлууд 74.3 сая төгрөг
- Байр ашиглалтын зардал 294.6 сая төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.



СУРГАЛТТАЙ ХОЛБООТОЙ ШУУД ЗАРДАЛ

Сургалттай холбоотой зардлын гүйцэтгэл 48,231.6 сая төгрөг гарч төлөвлөснөөс 3,055.7 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсны 1,507.1 сая төгрөг нь сургалттай холбоотой шууд зардлын цалин, НДШ-ийн зардал, 947.0 сая төгрөг нь хичээл практикийн зардал, 294.0 сая төгрөг нь байр ашиглалтын зардал, үлдэгдэл 307.0 сая төгрөг нь сургалттай холбоотой бусад зардлууд /гадаад дотоодын магадлан итгэмжлэл, багшийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх, ном хэвлэл/ байна.

Сургалттай холбоотой шууд зардлын 83.3 хувийг багш, цагийн багш, сургалтын албаны ажилтны үндсэн цалин, нэмэгдэл цалин, илүү цагийн хөлс эзэлж байна. Үүнд ЕБАС, КТК багтсан.

Сургалттай холбоотой цалин, нэмэгдэл, шимтгэлийн зардал 48.2 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 3.9 хувиар буюу 1.5 тэрбум төгрөгөөр дутуу гарсан. Үүнд:

- Үндсэн цалин 770.3 сая төгрөгөөр,
- Илүү цагийн хөлс 41.8 сая төгрөгөөр,
- Цагийн багшийн хөлс, гэрээт багш, ахмад багшийн цалин нэмэгдэл 198.2 сая төгрөгөөр
- Нэмэгдэл 330.7 сая төгрөгөөр,
- НДШ 166.1 сая төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй гарчээ.

Хичээл практикийн зардал 4.5 тэрбум төгрөгт хүрч, урьд оны гүйцэтгэлээс 10.6 хувь буюу 425.7 сая төгрөгөөр өсөж, төсвөөс 17.5 хувь буюу 947.0 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Хичээл сургалт, лабораторийн зардал 567.4 сая төгрөг, сургалтын тоног төхөөрөмж худалдан авах зардал 185.0 сая төгрөг, дадлагын зардал 46.9 сая төгрөг, сургалтын бичиг хэргийн зардал 74.8 сая төгрөг, интернетийн зардал 14.7 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарчээ.

Ном хэвлэлийн зардалд 183.9 сая төгрөг зарцуулсан нь төлөвлөснөөс 17.1 хувь буюу 37.8 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Тайлант онд багш нарын мэргэжил дээшлүүлэх, багшийн дэмжих зардалд 361.7 сая төгрөгийг төсөвлөж 82.9 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.



ШУУД БУС ЗАРДАЛ /сая.төг/

